

84821

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

89-1

СС-ийн номын сан  
СС-ийн Үндсэн фонд  
025 Н 72



SSM425

НОМЫН САНЧДЫН  
ЛАВЛАХ

X

ЗУУНМОД ХОТ  
1987

БНМАУ-ын АИХ-ын II дэх удаагийн  
сонгуулийн 4 дүгээр чуулганд зориулав

T2010  
10

1975

# НОМЫН САНЧДЫН ЛАВЛАХ

Төв аймгийн АДХ-ын гүйцэтгэх  
захиргааны Соёлын хэлтэс

Эмхэтгэсэн

П. МӨНХТУЯА

Редактор

С. ЦЭЕННЯМ

Зүүмод хот

1987 ОН



## БНМАУ-ЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

1974 оны 9 дүгээр  
сарын 6-ны өдөр

Дугаар 342

Улаанбаатар  
хот

Номын сангийн талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Номын сангийн материаллаг баазыг  
бэхжүүлж, хөдөлмөрчдөд номын сангаар  
үйлчлэх ажлыг цаашид сайжруулах зорил-  
гоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс  
ТОГТООХ НЬ:

1. Номын сангийн зэргийг дор дурдса-  
наар өөрчлөн тогтоосугай.

а/ нэгдүгээр зэргийн номын сан нь  
150,0 мянгаас дээш номтой, үйлчилгээний  
нэг номын санч жилд 1,5 мянган байнгын  
уншигчдад үйлчилж, 18 мянган ном ун-  
шуулж, фондын бүх номын 30 хувийг  
ашигласан байх.

б/ хоёрдугаар зэргийн номын сан нь  
90—150 мянган номтой, үйлчилгээний  
нэг номын санч жилд 1,3 мянган уншигч-  
дад үйлчилж, 15,6 мянган ном уншуулан  
фондын бүх номын 40 хувийг ашигласан  
байх.

в/ гуравдугаар зэргийн номын сан нь  
40—90 мянган номтой, үйлчилгээний нэг  
номын санч жилд 1,1 мянган байнгын ун-



шигчдад үйлчилж, 12,2 мянган ном уншуулан, фондын бүх номын 50 хувийг ашигласан байх.

г/ дөрөвдүгээр зэргийн номын сан нь 20—40 мянган номтой, үйлчилгээний нэг номын санч жилд 900 байнгын уншигчдад үйлчилж, 10,8 мянган ном уншуулан фондын бүх номын 60 хувийг ашигласан байх.

д/ тавдугаар зэргийн номын сан нь 5—20 мянган номтой, үйлчилгээний нэг номын санч жилд 560 байнгын уншигчдад үйлчилж, 6,7 мянган ном уншуулан фондын бүх номын 70 хувийг ашигласан байх.

2. Соёлын яаманд даалгах нь:

а/ дээр заасан ёсоор 1975 оноос улсын нийт номын сангийн зэргийг шинэчлэн тогтоож, паспорт. тодорхойлолттой болгох арга хэмжээ авсугай.

б/ номын сангийн дүрэм, уншлага үйлчилгээний журмын тухай заавар, холбогдох маягт, загварыг 1975 онд багтаан шинэчлэн баталж гаргах арга хэмжээ авсугай.

в/ номын сангийн фонд, каталог зохион байгуулах, ном ангилах, тодорхойлох нэгдсэн систем тогтоож, шинээр хэвлэгдэж байгаа ном бүрийг индекстэй гаргаж байсугай.

г/ номын сангийн мэргэжлийн болон ном зүйн холбогдолтой сурах бичиг, гарын авлагыг 1975—1980 онд багтаан боловсруулж гаргасугай,



3. Номын сангийн дээд мө  
оноос эхлэн ах дүү социалист оронд оюу-  
тан явуулан сургахыг улсын төлөвлөгөөний  
комисс, Соёлын яаманд даалгасугай.

4. Орчин үеийн шаардлагад тохирсон  
номын сангийн нэг загварын барилгын зу-  
раг төсвийг Соёлын яаманд захиалгаар  
1975 онд багтаан гаргаж өгөхийг Барилга-  
Архитектурын комисст даалгасугай.

Соёлын яамны сайдын 1975 оны  
18 дугаар тушаалаар батлав;

**«НОМЫН САНГИЙН АЖЛЫГ  
САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ» ТОГТООЛЫГ  
БИЕЛҮҮЛЭХ ЗААВРААС**

Нэг. Ерөнхий зүйл

1. БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байгаа  
улс, аймаг, сум—нэгдэл, сангийн аж ахуй,  
хот, район, хорооны болон яам, тусгай газ-  
рын харьяанд байгаа бүх төрлийн номын  
сан, уншлагын газрыг шинэчлэн байгуулах,  
татан буулгах, улсын зэрэгт оруулах, унш-  
лага үйлчилгээ, соёл хүмүүжлийн ажил зо-  
хиох, номыг хадгалж хамгаалах судалж  
сурталчлах, бүртгэн тоолсх, уншиж ашиг-  
лах зэрэг үйл ажиллагааг энэ заавраар зо-  
хицуулна.

2. Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 388,



1974 оны 342 дугаар тогтоолыг биелүүлэх энэ заавар нь тус улсын нутаг дэвсгэрт ажиллаж буй бүх төрлийн нийт номын сан, уншлагын газарт хамаарагдана.

3. Аймаг, хот, хоршооллын болон яам, тусгай газар нь номын сан уншлагын газрын ажлыг зохих тогтоол зааврын дагуу зохион байгуулж, улсын зэрэгт оруулах уншлага үйлчилгээнд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь холбогдох байгууллагад мэдэгдэж байх үүрэг хүлээнэ.

4. Номын сан, уншлагын газрыг улсын төлөвлөгөөний үндсэн дээр шинээр байгуулах, төлөвлөгөө, бүртгэл тайлан тооцоо, номын сан татан буулгах асуудлыг Соёлын яам эрхлэн гүйцэтгэнэ.

Хоёр. Номын санг бүртгэх, зэрэг тогтоох журам

5. БНМАУ-ын номын сангийн бүрэлдэхүүнд дор дурдсан төрлийн номын сан хамаарагдана.

а) БНМАУ-ын нийтийн номын сан;

б) аймаг, хотын нийтийн номын сан;

в) сум—нэгдлийн номын сан;

г) МҮЭ-ийн төв зөвлөлийн харьяа САА-н номын сан

д) Ардын боловсролын яам, Улсын дээд, тусгай дунд, техник мэргэжлийн боловсролын хорооны харьяа их, дээд, техникум, техник мэргэжил, ерөнхий боловсролын сургуулийн номын сан;



га бүрдүүлэн 2 хувь үйлдэж Соёлын яанд нэг хувийг хадгална.

13. Номын санд зэрэг тогтоолгох ажлын материалыг аймаг, хотын соёлын хэлтийн дарга, сум, район, хорооны гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн дарга нар бүрдүүлнэ. Тэд ажлаас чөлөөлөгдвөл дараагийн хүнд баримт материалыг заавал хүлээлгэн өгнө.

Гурав. Ном товхимлыг судалж сурталчлах ашиглах журам

14. Номын сангийн фондын номыг бүртгэж тоолох ажлыг аймаг, хотын соёлын хэлтэс эрхлэн гүйцэтгэнэ.

Тооллогыг явуулахдаа Соёлын яамны баталсан „Фондын ном тоолох заавар“-ыг үндэслэн гүйцэтгэнэ.

15. Ард иргэдийн зөвшөөрснөөр өмчинд байгаа ховор чухал ном товхимлыг номын санд түр буюу бүрмөсөн бүртгэн авч ашиглуулж болно.

16. Номын сангийн номын фондод хадгалагдаж байгаа ном товхимлыг бусдад бэлэг дурсгал болгох, худалдах зэргийг хатуу хориглоно.

17. Хөдөлмөрчдийн унших судлах, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий ховор чухал ном товхимлыг хувилж микрофильмээр олшруулах асуудлыг Соёлын яамны зохих шийдвэрийг үндэслэн гүйцэтгэнэ.



18. Номын санг дор дурдсан зориулалтын танхим, тасагтайгаар ашиглана.

1. Нэгдүгээр зэргийн номын санд
    - а) монгол номын фонд;
    - б) орос ба бусад гадаад номын фонд;
    - в) архив, солилцоо, тогтмол хэвлэлийн фонд;
    - г) номын сангийн судлалын тасаг;
    - д) номын зүйн ажлын тасаг;
    - е) ном гэрээр олгох танхим (2 ээлж)
    - ж) нийтийн уншлагын танхим (2 ээлж)
  - 3) эрдэм шинжилгээний уншлагын танхим
  - и) хүүхдийн уншлагын танхим
2. Хоёрдугаар зэргийн номын санд
    - а) орос, монгол номын фонд
    - б) номын сангийн судлалын тасаг
    - в) ном зүйн ажлын тасаг
    - г) гэрээр (ном) олгох танхим (2 ээлж)
    - д) нийтийн уншлагын танхим (2 ээлж)
    - е) эрдэм шинжилгээний уншлагын танхим
    - ж) хүүхдийн уншлагын танхим
3. Гуравдугаар зэргийн номын санд
    - а) орос, монгол номын фонд
    - б) номын сангийн судлалын тасаг
    - в) ном гэрээр олгох танхим
    - г) нийтийн уншлагын танхим (2 ээлж)
    - д) хүүхдийн уншлагын танхим
4. Дөрөвдүгээр зэргийн номын санд
    - а) орос, монгол номын фонд
    - б) номын сангийн судлалын тасаг



в) ном гэрээр олгох, нийтийн уншлагын танхим

г) хүүхдийн уншлагын танхим

5. Тавдугаар зэргийн номын санд

а) орос, монгол номын фонд

б) номын сангийн судлалын тасаг

в) ном гэрээр олгох, нийтийн ба хүүхдийн уншлагын танхим

19. Дээрх номын сангийн уншлага үйлчилгээтэй холбогдсон дүрэм, заавар, данс бүртгэл, карт, тооцоо судалгаа тооллогын заавар маягт загварыг Соёлын яам батална.

20. Номын сангийн фонд, товъёог зохион байгуулах, ангилах, тодорхойлох нэгдсэн систем тогтоох, шинээр ажлыг Соёлын яам эрхлэн гаргана.

21. Аймаг, хотын нийтийн номын санг байр тоног төхөөрөмжөөр хангах, номын фондыг арвижуулах зэрэг арга хэмжээний зардлыг аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаад хариуцна.

22. Сум-нэгдэл, САА, яам, тусгай газрын дэргэдэх номын сан, уншлагын газрын байр, тоног төхөөрөмж, номын фондыг арвижуулах төсөв, зардлыг харьяалсан байгууллага, газраас гаргаж санхүүжүүлнэ.

23. Улсын зэрэгт орсон номын сангийн орон тоо, цалингийн хэмжээг Хөдөлмөр цалин хэлсний улсын хорооноос баталсны дагуу олгоно.



24. Сум—нэгдэл, САА-н номын сангийн барилгыг Соёлын яамнаас зөвшөөрч Барилга—архитектурын комиссоос батлан гаргасан орчин үеийн шаардлагад тохирсон номын сангийн нэг загварын барилгын зураг төсвөөр барих бөгөөд зураг төсвийг дур мэдэн өөрчлөхийг хориглоно. Хэрэв засварлах, өөрчлөх шаардлагатай бол зохих газрын зөвшөөрөл авч гүйцэтгэнэ.

25. Номын сангийн барилгыг барих, шинэчлэн засварлах ажлыг аймаг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны захиалгын дагуу төв, орон нутгийн барилгын байгууллагын зохиож баталсан зураг төсвөөр гүйцэтгэнэ.

26. Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, ард иргэд эзэмшин ашиглаж байгаа гэрийн номын сан, ном хэвлэлээр номын санд сайн дурын үндсэн дээр бэлэглэх буюу зохих үнээр нь худалдаж болно.

Эдгээр ном зохиолыг номын сан худалдан авах, шилжүүлэх ажлыг Соёлын яамны баталсан „Нийтийн номын сангийн ном ашиглах дүрэм“-ийн дагуу гүйцэтгэнэ.

27. Улсын зэрэг бүртгэлд орсон номын сан, ховор чухал ном зохиол гал түймэр, ус, үер зэрэг гэнэтийн аюулд орж үрэгдэж гэмтвэл аймаг, хотын соёлын хэлтсийн тусгай комисс акт тогтоож, долоо хоногийн дотор зохих байгууллагад мэдэгдвэл зохино.



28. Номын сангийн ажилтан нар өөрийн эзэмшилд байгаа ном зохиолыг худалдах, бусдад шилжүүлэх, нуун далдлах, бэлэглэх, алдаж үгүй болгох зэрэг зөрчил гаргасан хүмүүсийг аймаг, хот, сум район, хороо, яам, тусгай газрын захиргаа номыг ижил нэр номоор нь төлүүлэх буюу үнийг авч улсын орлого болгож, хүндрэх шалтгаантай байвал хуулийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авч байна.

Соёлын яамны сайдын 1975 оны 18 дугаар тушаалаар батлав.

## НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ДҮРМЭЭС

Нэг. Ерөнхий зүйл

8. Номын сан бүр сард нэг удаа ариун цэвэр, дотоод ажлын өдөртэй байна.

9. Номын сан, фондын номыг тоолохдоо Соёлын яамны баталсан „Ном тоолох заавар“-ыг баримтлан гүйцэтгэнэ.

10. Утга агуулгаар хуучирсан буюу гэмтсэн номыг фондоос хасахдаа Соёлын яамнаас баталсан „Фондоос ном хасах заавар“-ыг баримтална.

Хоёр. Номын сангийн ажлын зорилт, агуулга

1. Номын сангийн ажлын зорилт бол марксист—ленинист үзэл санаа, шинжлэх